

БАТЛАВ.
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ


С.ЭНХ-ЭРДЭНЭ

2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

СТ7460 0623010010

**“ТАНД ОЙРХОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ
ӨДӨРЛӨГ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

1.1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ойртуулж төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, салбарын бодлого, чиглэл, үйл ажиллагаа, хууль эрх зүйг сурталчлан таниулах, мэдээ мэдээлэл, зөвлөмж зөвөлгөө өгөх, санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн төр, иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Зорилт

2.1. Улсын бүртгэлийн хэлтсээс төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор шинэ тоног төхөөрмжийг Замын-Үүд сумын улсын бүртгэгчид гардуулж өгөх, пасс машины үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх, Замын-Үүд сумын оршин суугч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх;

2.2. Иргэдийн санал хүсэлтийг сонсох, сэтгэл ханамжийн судалгаа авах тулгамдаж буй асуудлыг тухай бүр түргэн, шуурхай шийдвэрлэх

2.3. Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж иргэд олон нийтэд цогц үйлчилгээ үзүүлэх;

Гурав. Хамрах хүрээ

3.1. Дорноговь аймаг Замын-Үүд сумын аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийтэд;

Дөрөв. Зохион байгуулагч

4.1. Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс;

Тав. Оролцогч байгууллага

5.1. Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Замын-Үүд сум Засаг даргын тамгын газар, Замын-Үүд сумын газрын даамал;

Зургаа. Байршил, Хугацаа

6.1. Замын-Үүд сумын ЗДТГ, 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00-16:00 цаг хүртэл зохион байгуулагдана;

Долоо. Арга хэмжээ болон үйлчилгээний төрөл

7.1. Улсын бүртгэлийн дараах лавлагаа, үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллана. Үүнд:

- Иргэний цахим үнэмлэхийн захиалга авах

- Хэвлэгдэж ирсэн үнэмлэхийг олгох
- Гадаад паспортын захиалга авах
- Хэвлэгдэж ирсэн паспортыг олгох
- Иргэдэд тоон гарын үсэг олгох

- Төрсний , үрчлэлт, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчлөлт, эцэг, /эх/ тогтоосны бүртгэл, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болсны, нас барсны, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухай бүр гүйцэтгэх,

- Үл хөдлөх, эд хөрөнгө шинээр бүртгүүлэх, гэрээ /барьцааны гэрээний бүртгэл, худалдах, худалдан авах, бэлэглэх, өвлөх эрхийн/-ний үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлийг тухай бүр гүйцэтгэх,

- Өмчлөлийн газрыг шинээр бүртгэх, гүрээ /барьцааны гэрээний бүртгэл, худалдах, худалдан авах, бэлэглэх, өвлөх эрхийн/-ний үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлийг тухай бүр гүйцэтгэх,

- Шинээр хуулийн этгээд бүртгэх,

- Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах,

- Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийх,

- Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчлийг тухай бүр хянан шийдвэрлэх,

- Улсын бүртгэлийн лавалгаа үйлчилгээ /Бүх төрлөөр/,

- Улсын бүртгэлийн байгууллагын цахим үйлчилгээний талаарх зөвөлгөө, мэдээлэл өгөх,

- Хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгаа авах,

- Иргэдийн санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэх,

Найм. Оролцогч байгууллагын үйлчилгээ

8.1. Цахим шилжилтийн талаарх мэдээ, мэдээллийг түгээх, хууль эрх зүйн орчныг сурталчилан таниулах;

8.2. Бусад;

ЕС. Тайлагнах

9.1.Тус арга хэмжэг зохион байгуулсан тухай илтгэх хуудас, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэн удирдамжийн дагуу Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг хэлтсийн даргад тайлагнана.

9.2.“Танд ойрхон төрийн үйлчилгээ” өдөрлөгийн үйл ажиллагаанаас гарсан үр дүнг Улсын бүртгэлийн ерөнхий газар болон аймгийн засаг даргад хүргүүлэх.

Боловсруулсан:



Б.Баттуяа

**ТАНД ОЙРХОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС**

2025 оны 09 дүгээр сарын 11

Сайншанд хот

№	Үйл ажиллагаа	Хариуцах албан тушаалтан	Анхаарах асуудал
1	Асар, 6 ширээ, ширээний бүтээлэг бэлдэх, чихэрийн таваг	С.Шүрэндулам, Б.Мөнх-Учрал	Нээлттэй хаалганы өдөрлөг хийхэд бэлэн болгох
2	Тараах материал, гарын авлага, санал хүсэлтийн QR, Иргэний бүртгэлийн гарын авлага QR, хэвлэж бэлтгэх /өнгөтөөр/	П.Азжаргал	3 бүртгэлээр гарын авлага хэвлэх
3	Банар, анонс бэлдэх	П.Азжаргал, Ж.Болортуяа	Хэвлэгдсэн банар болон анонсыг бэлдэх
4	Тоног төхөөрөмж, үнэт цаас, 4G төхөөрөмж бэлдэх	Явах албан хаагчид, П.Азжаргал	Тоног төхөөрөмжийг бэлэн болох
5	Тээврийн хэрэгсэл болон бензин бэлдэх	У.Буянбат	Машин бэлдэх
6	Скайнар болон нотебүүк бэлдэх	П.Азжаргал	Тоног төрөөхөмжийн бэлэн байдлыг хангах